



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

ТАБ-ын Дарга, Тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа
Утас: 70543156
Цахим хаяг: saraa_audit@yahoo.com

Ахлах аудитор: Д.Оюунбат
Утас: 70543151
Цахим хаяг: oyuna200702@yahoo.com

ТАБ-ын хаяг: ГСА, Сүмбэр сум 3-р
баг, Нутгийн удирдлагын ордон

Байршил: Нутгийн удирдлагын ордон
2 давхар

Цахим хуудас: www.govisumber.audit.gov.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	2
Нэг. Ерөнхий зүйл	
Аудит хийсэн үндэслэл, хугацаа.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ.....	5
Аудитын арга зүй.....	5
ОН-ийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал.....	5
Хоёр. Санхүүгийн дотоод хяналт	6
Гурав. Шилэн дансны мэдээлэл.....	7
Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох.....	8
Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар.....	8
Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	
6.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар	8
6.2. Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах дансны талаар	9
6.3 Аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар.....	10
Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал	
7.1. Авлагын бүтцийн талаар.....	11
7.2. Аймгийн ТЭЗ-ийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагын бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар.....	12
Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал	
8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар	14
8.2 Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалын зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар.....	14
Ес. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал	
9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар.....	15
9.2 Аймгийн ТЭЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар	17

Арав. Өр төлбөрийн бүртгэл тайлагналын

10.1. Өр төлбөрийн бүтцийн талаар	18
10.2. Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар	19

Арван нэг. Орлогын бүртгэл тайлагнал20

11.1 Аймгийн ТЕЗ-ын 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар	21
11.2 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар.....	21
11.3 Бусад эх үүсвэрийн талаар.....	24

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал.....25

12.1 Зардлын бүтцийн талаар	26
12.2 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчлүүдийн талаар.....	28

**Арван гурав. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай
холбоотой гарсан зөрчлүүдийн талаар**25**Арван дөрөв: Хуримтлагдсан үр дүнгийн талаар.....**26**Арван тав: Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн
нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар
илэрсэн зөрчлийн нэгтгэл**26**Арван зургаа: Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт.....** 26**Арван долоо. Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн
нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт.....**26**Арван найм. ҮАГ-т уламжлах санал** 27

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
АХС	Аймаг хөгжүүлэх сан
БХС	Байгаль хамгаалах сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖМС	Жижиг мөнгөн сан
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
ЗДНС	Засаг даргын нөөцийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХС	Мал хамгаалах сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНСНТ	Орон нутгийн санхүүгийн нэгтгэсэн тайлан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СНТ	Санхүүгийн нэгтгэсэн тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СХС	Сум хөгжүүлэх сан
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн ОУС
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХО	Хөрөнгө оруулалт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ГСА-/2016/01-СТА-ТЕЗ / аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг бүрэн ирүүлсэн бөгөөд эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт болно.

Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай шилжүүлгийн байгууллагууд, ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан, төсөл сангуудын нийт 59 тайланг хамруулан нэгтгэсэн тайланг аудитласан болно. Үүнд:

- Орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлан 13
- Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлан 22
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын санхүүгийн тайлан 4
- Төсөл, сангуудын санхүүгийн тайлан 20

Аудитын арга зүй

Орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

Орон нутгийн 2016 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-ыг баримтлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан

аккруэл суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ОН-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	Үндсэн хөрөнгө, бараа материал, өр, авлагын тодруулга тайлан байгууллагын төрлөөр
ОН-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	
ОН-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
ОН-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Дээрх тайлангуудаас Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаас бусад тайланг Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ын дагуу “Э-тайлан” програмаар бэлтгэн гаргажээ.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Санхүүгийн хяналт, аудитын алба” аймгийн ЗДТГ-ын бүтцэд байгуулагдаж, 2016 онд нийт 11 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг хамруулан шалгаж, 9.4 сая төгрөгийн зөрчил дутагдал илрүүлж, 3 акт бичиж, зөрчил дутагдлыг арилгах 8 зөвлөмж, 2 албан шаардлага өгч ажилласан байна.

Тухайн тайлант хугацаанд хийгдсэн хяналт шалгалтаар нийтлэг дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Албан томилолтын хуудасны хоногийн тоог зассан, зардлыг илүү, дутуу олгосон, анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй. /Засгийн газрын 218-р тогтоолын 1-р хавсралтаар баталсан журмын 12-р заалт/
- Автомашины шатахууны зарцуулалтыг тооцохдоо нормоос илүү бодож олгосон, замын хуудас бичээгүй /Дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалаар батласан жишиг норм/
- Байгууллагын дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг зарим байгууллага огт хэрэгжүүлээгүй, зарим байгууллага нь дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч шаардлага хангахгүй байгаа, зөвхөн үндсэн үйл ажиллагаандаа хяналт тавьж, санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлж чаддаггүй. /ЗГ-ын 311-р тогтоол/
- Байгууллагын удирдлагууд тушаал шийдвэр гаргахдаа хүчингүй болсон хууль тогтоомжийг хэрэглэсэн,
- Ажлаас халагдсан ажилтнуудтай ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс ээлжийн амралтын олговор дутуу олгодог, мөн ээлжийн амралтын мөнгийг илүү

бодож өмнөх жилд бодсон амралтын мөнгийг давхардуулан тооцож олгосон. /Хөдөлмөрийн тухай хуулийн 55.1 дэх заалт/

- Өмнөх жилүүдийн мэргэжлийн хяналтын санхүүгийн хяналт шалгалтын актыг биелүүлээгүй,
- Ажилчдад цалингийн урьдчилгааг хууль тогтоомжийн дагуу тооцож олгоогүйгээс өглөг, авлага үүсдэг, ажилчдаас авах авлагаа дутуу суутгадаг, /НББТХуулийн 14.4.2 дахь заалтыг/
- ХЭДСангийн эргэн төлөгдөх нөхцөлтэй олгож буй зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьдаггүй, зээл хугацаандаа төлөгдөөгүй, иргэдэд ямар нэг хариуцлага тооцоогүй,
- Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл хангалтгүй, үндсэн хөрөнгөө коджуулаагүй, элэгдлийн хугацаа дууссан буюу ашиглах хугацаа нь дууссан, цаашид ашиглах боломжгүй болсон хөрөнгийг холбогдох газарт нь санал хүргүүлж шийдвэрлүүлдэггүй, /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 зүйл/
- Нэг удаагийн тэтгэмж урамшууллыг хавтгайруулан олгодог, /Засгийн газрын 2004 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 112 дугаар тогтоол/
- Шагнал урамшууллыг олгохдоо ХХОАТатвар суутгадаггүй, /Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 16.1.1, 23.1, 26.1.1 дэх заалтууд/
- Ажилчдыг ажлаас үндэслэлгүй ажлаас халдаг.

Дээрх зөрчлүүдийн улмаас Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаалууд зөрчигдсөн байна.

Орон нутгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 50 байгууллагын дотоод хяналтын эрсдэл “Хэвийн” гэж үнэлэгдсэн бол 5 байгууллагыг “Хангалтгүй” гэж дүгнэсэн байна.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

2016 онд төсвийн болон орон нутгийн өмчит 74 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж тайлан мэдээг улирал бүр Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газарт хүргүүлсэн байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу харьяа 74 байгууллагаас түүвэрчлэн 34 байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд 264.1 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 154.1 сая төгрөгийн зөрчлийг шалгалтын явцад залруулсан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд:

- Програмаас байгууллагууд татагддаггүй. /ШДТХуулийн 5.1.2 заалт/
- Цалингаас бусад 5 сая төгрөгнөөс дээш орлого, зарлагыг мэдээлээгүй /ШДТХуулийн 6.4.5 заалт
- Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн тайлбар бичээгүй. /ШДТХуулийн 6.3.3 заалт/
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг хийдэггүй. /ШДТХуулийн 6.4.1 заалт/
- 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий бараа, худалдан авсан бараа ажил үйлчилгээний нэр, нийлүүлэгчдийн нэр хаягийг огт бөглөдөггүй. /ШДТХуулийн 6.4.4 заалт/ зэрэг зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүрээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор” гэснийг зөрчсөн байна.

Цаашид “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг сайжруулах, байгууллагуудын шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтнуудыг нэгдсэн нэг ойлголттой болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгийн дүнг суурь болгон авч түүний 1.0 хувиар тооцон 352.0 сая төгрөгөөр тогтоов.

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсөвт байгууллага, тусгай шилжүүлгийн байгууллага, төрийн сан, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөл, сангуудын нийт 59 байгууллагын тайланг хамрууллаа.

Орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг хавсарч ирүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т “төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланг аймгийн Аудитын газарт дээрх хугацаанд ирүүлсэн болно.

Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Говьсүмбэр аймгийн орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын нярвын данс, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨААТҮГ-ууд болон төсөл сангийн үлдэгдэл,
- ОНӨААТҮГ-уудын кассад байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл.

Орон нутгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2016 оны эцэст 1,035.9 сая төгрөг байсан ба тайлант оны эцэст 2,182.1 сая төгрөг болж 110.6 хувь буюу 1,146.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт үлдэгдлийн 96.8 хувь нь төрийн сангийн нэгдсэн дансанд, 0.1 хувь нь аж ахуй нэгжийн касст, 3.1 хувь нь арилжааны банкинд байршиж байна.

Орон нутгийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2016 оны үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө					
Төгрөг/ЖМС	2.3	1.4	1.4		
Касс					
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,033.6	2,180.7		66.8	2,113.9
Төгрөг	1,033.6	2,180.7		66.8	2,113.9
Гадаад валют					-
Замд яваа мөнгөн хөрөнгө					-
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	1,035.9	2,182.1	1.4	66.8	2,113.9
<i>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</i>					
Төрийн сан	658.9	1,004.4		0.3	1,004.1
Төсөвт байгууллагууд	194.8	810.2		17.0	793.2
ОНӨҮГ	6.9	50.9	1.4	49.5	
Төсөл, сангууд	175.3	316.6			316.6

Хүснэгтээс харахад: Төсөвт байгууллагуудын тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь өмнөх оноос 615.4 сая, төрийн сан дахь дансдын үлдэгдэл 345.5 сая, төсөл сангийн үлдэгдэл 141.3 сая, ОНӨААТҮГ-уудын үлдэгдэл 44.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

6.2 Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах дансны талаар

Төсвийн тухай хуулийн дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад сумдын орон нутгийн орлогын дансууд үлдэгдэлгүй, харин аймгийн орон нутгийн орлогын данс 0.3 сая, Халамжийн сангийн данс 17.0 сая, ОНӨААТҮГ-уудын данс 50.8 сая төгрөг, нийт 68.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Арилжааны банкуудад байршиж буй харилцах дансны үлдэгдлийг хураангуйлан харуулбал:

(сая төгрөгөөр)

АЙМАГ	ҮЛДЭГДЭЛ									НИЙТ ҮЛДЭГДЭЛ /сая.төг/	НИЙТ ДАНСНЫ ТОО
	Бэлэн мөнгөний касс	Жижиг мөнгөн сан	Зөвшөөрөлгүй	ОН-ийн орлого	ОН-ийн халамж	ОН-ийн өмчит үйлдвэрийн газар	Санхүүжилтийн данс	Төсөл сан	Хаагдсан		
Говьсүмбэр	1.4	-	-	0,3	17.0	49.5	-	-	-	68.2	16
НИЙТ ДҮН	1.4	-	-	0,3	17.0	49.5	-	-	-	68.2	16

Арилжааны банк дахь үлдэгдэл нь орон нутгийн орлогын үлдэгдэл байгаа бөгөөд үлдэгдлийн 45.8 хувь буюу 0.130 сая төгрөг нь Төрийн банкинд, 53.5 хувь буюу 0.152 сая нь ХААН банкинд, 0.7 хувь буюу 0.002 сая төгрөг нь Хас банкинд байршиж байна.

Эдгээр орлогын үлдэгдэл нь Төрийн сан 4 цагаас гүйлгээ хаадагтай холбоотой бөгөөд банкууд үлдэгдлийн тохируулга хийдэггүй, өөрийн үлдэгдлээр тайлагнаж, төсөвт орлого хүлээн зөвшөөрч бүртгэх боломжгүй байна.

Арилжааны банкин дахь орлогын үлдэгдлийн 85.6 хувь буюу 0,24 сая төгрөг нь ХХОАТ-ын, 14.4 хувь буюу 0,04 сая төгрөг нь ҮХЭХАТ-ын үлдэгдэл байна.

6.3. Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар

Аймгийн ТЕЗ-ын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, зарцуулалттай холбоотой нийт **609.2** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **1.7** сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **1.7** сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, **154.5** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **451.2** сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 41.2 хувь буюу **250.8** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 58.8 хувь буюу **358.4** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Халамжийн сангийн төсвийг үндэслэлгүй өндөр төлөвлөснөөс өмнөх онд **335.0** сая, тайлант онд **281.8** сая төгрөгийн хэмнэлт үүсч төвлөрүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

- Байгууллагуудын өмнөх оны төсвийн урамшууллын **76.6** сая төгрөгийг 2016 оны төсвийн хуваарьт оруулж баталснаас тайлант оны төсвийн гүйцэтгэлээр тайлагнагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.-т “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

- Арилжааны банк болон аймаг, сумдын төрийн сангийн ажлын уялдаа холбоо муугаас арилжааны банкаар дамжуулан цалингийн гүйлгээг хийхдээ төрийн сангаар хянуулсан тэмдэглэгээтэй цалингийн жагсаалтыг сольж өгсөнөөс төсвийн хөрөнгө шамшигдах, хувьдаа завших зөрчил дутагдал гарч байна. Мөн төсөвт байгууллагын нягтлан бодогч нар татвар, нийгмийн даатгалын тайланд цалингийн мэдээллийг буруу тайлагнадаг зөрчил дутагдал түгээмэл гарч байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.4-т “хүчин төгөлдөр

бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, 20.2.13-т “эрх бүхий байгууллагаас баталсан мэргэжлийн ёс зүйн дүрмийг баримтлан ажиллах” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал

7.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын эхний үлдэгдэл 1,728.9 сая төгрөг байсан бол тайлант онд 11.1 хувь буюу 192.5 сая төгрөгөөр буурч, оны эцэст 1,536.4 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	7.3	6.6	-0.7	-9.6
Байгууллагаас авах авлага	1,381.5	1,178.9	-202.6	-14.7
Хувь хүмүүсээс авах авлага	340.1	350.9	10.8	3.1
НИЙТ ДҮН	1,728.9	1,536.4	-192.5	-11.1

Хүснэгтээс харахад: нийт авлагын 76.7 хувийг байгууллагаас авах авлага, 22.8 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 0.5 хувийг ажиллагчидтай холбоотой авлага эзлэж байна.

Хувь хүмүүсээс авах авлагын эцсийн үлдэгдэл эхний үлдэгдлээс 3.1 хувь буюу 10.8 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад авлага 9.6-14.7 хувиар буурсан байна.

Авлагыг аймаг, сумдаар нь дараах хүснэгтээр харуулбал:


(сая төгрөгөөр)

Аймаг, сумдын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар	Нийт үлдэгдэлд эзлэх хувь
Аймаг	374.1	184.8	-189.3	-50.6	12.0
Сүмбэр сум	1,008.2	986.2	-22.0	-2.2	64.2
Баянтал сум	181.7	189.9	8.2	4.5	12.4
Шивээговь сум	165.0	175.5	10.5	6.4	11.4
НИЙТ ДҮН	1,729.0	1,536.4	-192.6	-11.1	100.0

Хүснэгтээс харахад: Аймгийн авлага 50.6 хувь, Сүмбэр сумын авлага 2.2 хувиар тус тус буурч, Баянтал сумын авлага 4.5 хувь, Шивээговь сумын авлага 6.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Нийт авлагад аймаг, сумдын авлагын эзлэх хувийг диаграммаар харуулбал:

Авлагын нийт үлдэгдэлд эзлэх хувь



Диаграммаас харахад: нийт авлагын 12.0 хувийг аймаг, 64.0 хувийг Сүмбэр сум, 12.0 хувийг Баянтал сум, 12.0 хувийг Шивээговь сум тус тус эзэлж байна.

Нийт 1,536.4 сая төгрөгийн авлага нь 91-ээс дээш хоногийн насжилттай байгаа бөгөөд авлагын 7.6 хувь буюу 117.6 сая төгрөг нь ТШЗ, 84.1 хувь буюу 1,291.8 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сан, 8.3 хувь буюу 127.0 сая төгрөг нь ОНӨААТҮГ-уудын авлагын үлдэгдэл эзэлж байна.

7.2 Аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагын бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагатай холбоотой **386.0** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнээс аудитын явцад **201.7** сая төгрөгийн зөрчил дутагдлыг залруулж, **0,07** сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, **42.2** сая төгрөгийн зөрчил дутагдал арилгуулах албан шаардлага хүргүүлж, **142.0** сая төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 95.6 хувь буюу **368.9** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 4.4 хувь буюу **17.1** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд аймгийн Аудитын газраас хийгдсэн Гүйцэтгэлийн аудитаар Баянтал сумын 4 дүгээр сургуулийн хүнсний материалаас 17.1 сая төгрөгийн бараа материалд акт тавигдаж, дээрх хэмжээгээр хүнсний материалын үлдэгдлээс хасах тухай албан шаардлага хүргүүлсэн боловч данснаас хасалт хийхдээ авлагаар бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн бөгөөд АОУС 210 “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал**8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар**

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл 1,544.6 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,576.3 сая төгрөг болж тайлант онд бараа материалын үлдэгдэл 2.0 хувиар буюу 31.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

(сая.төгрөгөөр)

Бараа материалын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувь
Тусгай зориулалтын материал	127.8	177.3	49.5	38.7
Эм боох материал	11.5	11	-0.5	-4.3
Дуусаагүй үйлдвэрлэл			0	
Бэлэн бүтээгдэхүүн		0.1	0.1	
Бичиг хэргийн материал	29.7	26.9	-2.8	-9.4
Аж ахуйн материал	622.5	625.1	2.6	0.4
Сэлбэг хэрэгсэл	41.1	35.5	-5.6	-13.6
Түлш шатхуун, тослох материал	17	13.9	-3.1	-18.2
Барилга засварын материал	2.5	2.2	-0.3	-12.0
Хүнсний материал	79.7	42.7	-37	-46.4
Бусад хангамжийн материал	476.3	478.7	2.4	0.5
Мал амьтад	110.2	102.1	-8.1	-7.4
Нөөцийн бараа	27.5	61.5	34	123.6
НИЙТ ДҮН	1,545.80	1,577.00	31.2	2.0

Хүснэгтээс харахад: Тусгай зориулалтын бараа материал 49.5 сая, аж ахуйн материал 2.6 сая, бусад хангамжийн материал 2.4 сая, нөөцийн бараа материал 34.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, бусад бараа материал 3.1-37.0 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 2,273.9 сая төгрөгөөр нэмэгдсэн ба худалдаж авсан 1,979.2 сая, хандив тусламжаар 221.7 сая, шилжүүлж авсан 25.9 сая, бусад хэлбэрээр 47.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 2,242.7 сая төгрөгөөр хасагдсан ба зарцуулсан 1,896.8 сая, шилжүүлсэн 181.3 сая, акталсан 164.7 сая төгрөгөөр тус тус данснаас хасагдсан байна.

Нийт бараа материалын үлдэгдлийн 13.8 хувь буюу 291.5 сая төгрөг ОНӨААТҮГ, 81.0 хувь буюу 1,278.0 сая төгрөг төсөвт байгууллагууд, 5.2 хувь буюу 7.5 сая төгрөг төсөл сангийн дансанд бүртгэлтэй байна.

8.2 Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалын зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой нийт **18.5** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс

аудитын явцад **1.0** сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **0.1** сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, **13.6** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **3.8** сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 46.0 хувь буюу **8.5** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 54.0 хувь буюу **10.0** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Шивээговь сумын Мал хамгаалах сангийн дансанд бүртгэлтэй 3.1 сая төгрөгийн өвс, 6.9 сая төгрөгийн тэжээл, нийт 10.0 сая төгрөгийн нөөцийн өвс, тэжээлийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр зөвхөн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлын тэмдэглэлийг үндэслэж данснаас хассан зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлнэ”, 5.1.5-т “хариуцлагатай байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитад хамрагдсан байгууллагуудын бараа материалтай холбоотой зөрчил дутагдал нь Санхүүгийн байдлын тайлан дахь бараа материалын үлдэгдэл бараа материалын тодруулгын болон дэлгэрэнгүй тайлан дахь үлдэгдэлтэй зөрөх, үнэ төлбөргүй ирсэн бараа материалыг данс бүртгэлд тусгахгүй байх, бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинж чанартай эд зүйлийг бүртгэх, тооллогоор дутагдсан бараа материалыг эзэн холбогдогчоор төлүүлэхгүй шууд зардал болгох зэрэг бүртгэл, тайлагналтай холбоотой байна.

Эдгээр нь АОУС 210 “иж бүрэн байх”, “тодруулга ба толилуулга”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, 12 дугаар зүйлийн 12.4-т “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндрөөр төлүүлнэ” гэсэн заалтууд тус тус зөрчигдөж байна.

Ес. Үндсэн хөрөнгийн талаар

9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгө оны эхэнд 48,445.9 сая төгрөг байсан бол тайлант онд 18.8 хувь буюу 4,460.0 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 51,130.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

(сая.төгрөгөөр)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Нийт хөрөнгийн дүнд эзлэх хувь
Газар			0	
Барилга байгууламж	28,866.3	31,697.8	-2,831.5	59.6

Тээврийн хэрэгсэл	2,149.7	2,117.6	32.1	4.4
Машин тоног төхөөрөмж	5,022.8	5,350.3	-327.5	10.4
Тавилга эд хогшил	1,212.3	1,227.5	-15.2	2.5
Түүх соёлын дурсгалт зүйл	62.3	62.3	0.0	0.1
Дуусаагүй барилга	1,191.9	325.6	866.3	2.4
Номын фонд	116.2	116.2	0.0	0.2
Зам, гүүрийн байгууламж	3,377.0	3,643.1	-266.1	7
Биет бус хөрөнгө	392.9	468.2	-75.3	0.8
Бусад үндсэн хөрөнгө	6,054.4	6,121.9	-67.5	12.5
Дүн	48,445.9	51,130.9	-2,684.7	

Хүснэгтээс харахад: Нийт үндсэн хөрөнгийн 59.6 хувийг барилга байгууламж, 2.5 хувийг тавилга, эд хогшил, 10.4 хувийг машин тоног төхөөрөмж, 2.4 хувийг дуусаагүй барилга, 7.0 хувийг зам гүүрийн барилга байгууламж, 4.4 хувийг тээврийн хэрэгсэл, 13.7 хувийг биет бус болон бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд 4,460.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба үүнээс худалдан авсан 103.2 сая, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 1,958.6 сая, шилжүүлж авсан 220.0 сая, данснаас дансанд шилжүүлсэн 2,178.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт 1,775.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хасагдаж, 51,130.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тайлант онд 360.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 1,415.0 сая төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлж, 2,005.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Үндсэн хөрөнгийн бүтцийг диаграммаар харуулбал:



Диаграмаас харахад: Нийт үндсэн хөрөнгийн 60.0 хувийг барилга байгууламж, 13.0 хувийг бусад үндсэн хөрөнгө, 10.0 хувийг машин тоног төхөөрөмж, 7.0 хувийг зам гүүрийн байгууламж, 4.0 хувийг тээврийн хэрэгсэл, 3 хувийг тавилга эд хогшил, 2.0 хувийг дуусаагүй барилга тус тус эзэлж байна.

9.2. Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой тус тайланд нэгтгэгддэг байгууллагуудын аудитаар нийт **1,756.3** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрсэнээс аудитын явцад **401.8** сая төгрөгийн зөрчил дутагдлыг залруулж, **24.2** сая төгрөгийн албан шаадлага хүргүүлж, **1,330.3** сая төгрөгийн зөрчил дутагдал арилгах зөвлөмж өгсөн байна.

Нийт зөрчил дутагдлын 80.8 хувь буюу **1,419.4** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 19.2 хувь буюу **336.9** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Хөрөнгө бүртгэх тухай шийдвэр буруу гарснаас Сүмбэр сумын 2 дугаар сургууль аймгийн төрийн сангийн бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй байгаа 25.0 сая төгрөгийн барилгын зураг төсвийг давхардуулан бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав

- Сүмбэр сумын Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр худалдан авсан боржигин байшин, мотоцикл, булгийн ам хамгаалахаар хийсэн хашаа зэрэг нийт 11.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэснийг зөрчсөн байна. АОУС 210 “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага хүргүүлэв.

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлыг үндсэн хөрөнгийн дуусаагүй үйлдвэрлэл дансанд 300.6 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байсныг Сангийн яамнаас зөвлөмж өгсний дагуу бусад эргэлтийн хөрөнгө дансанд шилжүүлүүлэв.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав

Аудитад хамрагдсан байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдал нь үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв тусгахгүй байх, санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн болон элэгдлийн үлдэгдэл үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын үлдэгдэлтэй зөрүүтэй байх, үндсэн хөрөнгийн ангилал буруу бүртгэх, аудитын явцад хийсэн тооллогоор хөрөнгө дутагдах, ашиглагдаж байгаа хөрөнгийн ихэнх хувь нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байх зэрэг бүртгэл тайлагналтай холбоотой байна.

Эдгээр нь АОУС 210 “иж бүрэн байх”, “тодруулга ба толилуулга”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө НББОУС-ын дагуу үнэлж, дансанд тусгана” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Арав. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

10.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар:

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 843.7 сая төгрөг байснаас тайланд онд 44.6 хувь буюу 376.7 сая төгрөгөөр буурч, оны эцэст 467.1 сая төгрөг болсон байна.

Нийт өр төлбөрийн 93.1 хувь буюу 434.8 сая төгрөгийн өр төлбөр нь 30 хүртэлх хоногтой, 0.7 хувь буюу 3.3 сая төгрөгийн өглөг нь 31-60 хоногтой, 0.2 хувь буюу 1.0 сая төгрөгийн өр төлбөр нь 61-90 хоногтой, 6.0 хувь буюу 28.0 сая төгрөгийн өр төлбөр нь 91-ээс дээш хоногтой байна.

Өр, төлбөрийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
Богино хугацаат зээлийн өглөг	0.2	0.2	0	0.0
Ажилчидтай холбоотой өглөг	19.5	14.5	-5	-25.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	44.3	2.5	-41.8	-94.4
Байгууллагад өгөх өглөг	756.7	417.5	-339.2	-44.8
Хүмүүст өгөх өглөг	23.0	32.4	9.3	40.3
Нийт өр төлбөрийн дүн	843.7	467.1	-376.7	-44.6

Хүснэгтээс харахад: Ажиллагсадтай холбоотой болон бараа үйлчилгээний зардал, байгууллагад өгөх өглөг 5.0-339.2 сая төгрөгөөр буурсан бол хувь хүмүүст өгөх өглөг 9.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өглөгийн үлдэгдлийг сум тус бүрээр харуулбал:

/сая төгрөг/

д/д	Сумдын нэр	Нийт өр төлбөр		Зөрүү	Нийт дүнд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	Сүмбэр сум	210.6	70.2	-140.4	15.0
2	Баянтал сум	93.7	54.7	-39	11.7
3	Шивээговь сум	72.4	22.1	-50.3	4.7
4	Говьсүмбэр аймаг	467	320.1	-146.9	68.5
	Дүн	843.7	467.1	-376.6	

Хүснэгтээс харахад: Тайлант онд сумдын өр төлбөр 39.0-146.9 сая төгрөгөөр буурсан бөгөөд нийт өр төлбөрийн 15.0 хувийг Сүмбэр сум, 11.7 хувийг Баянтал сум, 4.7 хувийг Шивээговь сум, 68.5 хувийг аймгийн төвийн байгууллагууд эзэлж байна.

Аймаг, сумын нийт өр төлбөрт эзэлж байгаа хувь хэмжээг диаграмаар харуулбал:



Диаграммаас харахад: нийт өр төлбөрийн 15.0 хувийг Сүмбэр сум, 11.7 хувийг Баянтал сум, 4.7 хувийг Шивээговь сум, 68.5 хувийг аймгийн төвийн байгууллагууд эзэлж байна

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

(сая төгрөгөөр)

№	Байгууллагуудын төрөл	Эцсийн үлдэгдэл	Нийт дүнд эзлэх хувь
1	Төсөвт байгууллагууд	33.2	7.1
2	Төсөл сан	282.8	60.5
3	Төрийн сан	0	
4	Тусгай шилжүүлэгийн байгууллагууд	33.7	7.2
5	ОНӨААТҮГ	117.4	25.1
Дүн		467.1	

Хүснэгтээс харахад: нийт өр төлбөрийн 7.1 хувийг төсөвт байгууллагууд, 60.5 хувийг төсөл сан, 7.2 хувийг тусгай шилжүүлэгийн байгууллагууд, 25.1 хувийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд тус тус эзэлж байна.

Өмнөх онд нийт өр төлбөрийн дийлэнх хувийг төсөвт байгууллагуудын өр төлбөр эзэлж байсан бол тайлант онд төсөл сангийн өр төлбөр 60.0 хувийг эзэлж байна. Төсөл сангийн өр төлбөрийн 77.9 хувь нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын барьцаа хөрөнгийн өглөг байна.

10.2 Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудитаар өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **13.8** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **1.7** сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **0.8** сая төгрөгийн зөрчил дутагдалд төлбөрийн акт бичиж, **1.3** сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **10.0** сая төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 97.8 хувь буюу **13,5** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 2.2 хувь буюу **0.3** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Сүмбэр сумын 1 дүгээр сургууль 0.3 сая төгрөгийн өр төлбөрийг хууль эрхийн үндэслэлгүйгээр өмнөх оны үр дүнд хаасан зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн байна. Энэ нь АОУС “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулах

Өр, төлбөртэй холбоотой гарч байгаа зөрчил дутагдал нь ажиллагсдын цалингаас суутгах ХХОАТ, НДШ-ийг суутган тооцсон боловч холбогдох байгууллагуудад шилжүүлдэггүй, тооцоо нийлсэн актаар баталгажаагүй өр, төлбөрийг бүртгэж, тайлагнасан, ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж бүртгэдэггүйгээс өр төлбөрөө буруу тайлагнадаг зэрэг нягтлан бодогчийн ажлын хариуцлагатай холбоотой байна.

Эдгээр нь НББ-ийн тухай 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн байна. Энэ нь АОУС “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга”, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.2-т “Өр, авлага үүсгэхгүй байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

11.1. Аймгийн ТЕЗ-ын 2016 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар:

Орон нутгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нийт 19,924.2 сая төгрөгийн орлого, санхүүжилт бүртгэсэн байна. Энэ нь өмнөх оноос 3,629.5 сая төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын бууралтад үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн бууралт нөлөөлсөн байна.

Үр дүнгийн тайлангаарх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү	
			дүн	хувь
Татварын орлого	3,936.3	4,797.0	-860.7	(21.87)
Татварын бус орлого	353.6	719.6	-366.0	(103.51)
Төсөвт байгууллагын өөрийн орлого	606.3	937.3	-331.0	(54.59)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,592.1	2,396.5	5,195.6	68.43
Бусад арга хэмжээ болон зээлийн хүүгийн орлого	109.4	363.2	-253.8	(231.99)
ОНӨААТҮГ-ын цэвэр борлуулалт	521.1	479.9	41.2	7.91
Тусгай зориулалтын шилжүүлэг	7,107.6	7,758.3	-650.7	(9.15)
ОНХС-гийн шилжүүлсэн орлого	2,721.1	2,227.4	493.7	18.14
Санхүүгийн дэмжлэг	348.5	16.5	332.0	129.2
Нэмэлт санхүүжилтийн орлого	257.7	228.5	29.2	11.33
Үйл ажиллагааны орлогын дүн	23,205.2	19,924.2	3,629.5	15.64

/сая төгрөг/

Хүснэгтээс харахад: Орлогын бүрдүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад ОНХС-ийн шилжүүлгийн орлого, санхүүгийн дэмжлэг, нэмэлт санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, ОНӨААТҮГ-ын орлогууд тус тус буурч, тусгай зориулалтын шилжүүлэг, татварын болон татварын бус орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого, зээлийн хүүгийн орлогууд тус тус нэмэгдсэн байна.

11.1 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар:

2016 онд аймгийн ТЕЗ-ийн хэмжээнд нийт 16,828.0 сая төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, зарцуулахаар төлөвлөж, батлуулснаас 16,397.8 сая төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, нийт орлого, санхүүжилтийн төлөвлөгөө 430.1 сая төгрөгөөр тасарсан нь төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлсөн хүчин зүйл нь сумдын сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

2016 онд тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 7,758.3 сая, ОНХС-гийн санхүүжилт 2,227.4 сая, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 16.5 сая төгрөг нийт 10,002.2 сая төгрөгийн улсын болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг хийхээр төлөвлөж, 100 хувь буюу бүрэн санхүүжсэн байна.

Өмнөх оны тэнцлийн ашиг 658.6 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар оны эхэнд 1,036.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан ба тайлант онд нийт 18,992.4 сая төгрөгийн орлого бүртгэж, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр 15,193.0 сая, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээгээр 2,569.1 сая, санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр 84.1 сая нийт 17,846.2 сая төгрөгийн зарлага бүртгэж, 2,182.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Мөнгөн гүйлгээний нийт орлого 18,992.4 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүнээс төсөвт байгууллагуудын орлого, санхүүжилт 15,333.6 сая, нэмэлт дансны санхүүжилт 236.4 сая төгрөг бүртгэж, буцаан төвлөрүүлсэн буюу тохируулсан 3,422.5 сая төгрөгөөс бүрдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн орлого нь орон нутгийн төсвөөс 5,189.6 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 7,758.3 сая, ОНХС-гийн санхүүжилт 2,227.4 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 218.2 сая, туслах үйл ажиллагааны орлого 51.5 сая төгрөгөөс бүрдсэн байна.

Нэмэлт дансны орлого санхүүжилт нь НҮБ-аас 9.8 сая аймгийн БСГ-аас 23.9 сая, аймгийн Засаг даргын нөөц сангаас 10.5 сая архивын ажилчдын цалин 57.6 сая, ОНХС-аас төсөл хөтөлбөр, техник хяналтын зардалд 94.0 сая, харьяа дээд байгууллагуудаас 19.2 сая төсвийн урамшуулалд 0.4 сая, бусад хандив тусламжаар 20.9 сая, нийт 236.3 сая төгрөгийг тус тус хүлээн авч зарцуулсан байна.

2016 онд орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 4,934.9 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөснөөс 5,518.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 11.8 хувь буюу 583.8 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогын гүйцэтгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаар 5,515.6 сая төгрөг, аймгийн Татварын хэлтсийн мэдээгээр 5,519.3 сая төгрөгөөр тайлагнаж, 3.7 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь өмнөх оны болон тайлант оны арилжааны банкин дахь үлдэгдэл, замд яваа мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Энэ нь аймгийн Татварын хэлтэс орлогын тайландаа 2016 оны 12 дугаар сарын 31-нээр арилжааны банкнаас шилжүүлсэн, аймгийн Төрийн сангийн дансанд ондоо багтаж ороогүй 1.4 сая төгрөгийн орлогыг замд яваа орлогоор хүлээн зөвшөөрч, бүртгэж, тайлагнасантай холбоотой байна.

Тайлант оны орон нутгийн орлогоос 220.3 сая төгрөгийн ХХОАТ-ын буцаан олголт хийгдсэн байна.

Тайлант онд орон нутгийн орлогын төлөвлөгөө бүх нэр төрлөөрөө давж биелэгдсэн байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг аймаг болон сумдаар авч дараах хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/					
Д/д	Аймаг, сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүн	Хувь
1	Сүмбэр сум	195.2	221.3	-26.1	-13.4
2	Баянтал сум	13.4	10.7	2.7	20.1
3	Шивээговь сум	47.2	61.9	-14.7	-31.1
4	Говьсүмбэр аймаг	4,033.2	4,503.1	-469.9	-11.7
Нийт дүн		4,289.0	4,797.0	-508.0	-11.8

Хүснэгтээс харахад: орон нутгийн орлогын төлөвлөгөөг Баянтал сум 20.1 хувь буюу 2.7 сая төгрөгөөр тасалж, аймаг болон Сүмбэр, Шивээговь сум 13.4-31.1 хувь буюу 14.7-469.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

11.3. Бусад эх үүсвэрийн талаар:

Орон нутгийн орлогоос гадна төсөвт зардлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Орлогын бусад эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг дараах хүснэгтээр харуулбал:

(сая төгрөгөөр)				
Аймаг, сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
			Дүн	Хувь
Санхүүгийн дэмжлэг	16.4	16.4	-	
Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт	2,227.4	2,227.4	-	
Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт	7,758.3	7,758.3	-	
Тэнцлийн ашиг	658.6	658.6	-	

Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,232.1	218.3	1,013.8	82.2
Нийт дүн	11,892.8	10,879.0	1,013.8	

Хүснэгтээс харахад: төсөвт байгууллагын өөрийн орлогоос бусад эх үүсвэрүүд бүх нэр төрлөөрөө төлөвлөгөөний дагуу бүрэн санхүүжигдсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө их хэмжээгээр тасарсан нь сумдын сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгийн орлогыг төсвийн төлөвлөгөөнд оруулж төлөвлөдөг болсонтой холбоотой байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүний бүртгэл тайлагналтай холбоотой нийт **1,593.6 сая** төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **1,454.0** сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **7.2** сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, **10.5** сая төгрөгийн төлбөр зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, **121.9** сая төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 91.8 хувь буюу **1,463.9** сая төгрөг нь ТЕЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 8.2 хувь буюу **129.7** сая төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- НДС-аас орж ирсэн жирэмсэн амаржсаны тэтгэмжийн 15.9 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулж бүртгээгүйгээс тайлант хугацааны орлого, зардлаар тайлагнасан зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

- Сүмбэр сумын ОНХС-ийн 39.9 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлөхдөө тайлант хугацааны орлого, зардлаар бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

- ОНХС-аас байгууллагуудад олгосон 54.9 сая төгрөгийн төсөл, хөтөлбөрийн орлого, зардлыг ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд давхар бүртгэсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Зөвлөмж өгөх

- Түрээсийн орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй бөгөөд орлогыг 7.2 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлж, авлагаар бүртгээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-т “бүх орлого” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт бичив.

- Хөрөнгө борлуулсаны 1.3 сая төгрөгийн орлогыг арилжааны банк оны эцэст бууны албан татварын орлогын дансанд андуурч төвлөрүүлсэн ба газрын төлбөрийн 0,025 сая төгрөгийг АТӨЯХАТ-ын орлогоор тайлагнаж, орлогын нэр төрөл нийт 1,3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: 0.025 сая төгрөгөөр орон нутгийн орлогын нэр төрлийн зөрүүтэй тайлагнагдсаныг залруулж, залруулагдах боломжгүй 1.3 сая төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгөх

- ХААН банкнаас 1.0 сая төгрөгийн ХХОАТ-ын орлогыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр шилжүүлснээр ондоо багтаж төрийн санд ороогүй бөгөөд орлогыг замд яваа орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-т “бүх орлого” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

- Байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн 2.0 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг өглөгөөр бүртгээгүй, тайлант үеийн орлогоор тайлагнасан /Шивээговь сум 1.4 сая, Сүмбэр сум 0.6 сая / зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

- Данснаас дансанд шилжүүлсэн 7.4 сая төгрөгийн хөрөнгийг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх” гэснийг зөрчсөн ба АОУС 210 “хэмжилт”, “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулав.

Аудитын явцад орлогын бүрдүүлэлт, бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчил дутагдал нь орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлэгүй, үйл ажиллагааны орлогыг бүртгээгүй,

шууд зарцуулах, сум хөгжүүлэх сангийн зээлийн алданги, хүүгийн орлогыг дутуу тайлагнах, хөрөнгө бэлтгэх, ташаарч орсон мөнгийг орлогоор бүртгэх зэрэг нягтлан бодогчийн үйл ажиллагаатай холбоотой алдаа зөрчлүүд байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах чиг үүрэг хүлээнэ”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг зөрчиж байна.

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал

12.1. Зардлын бүтцийн талаар:

2016 онд аймгийн ТЕЗ-ийн төсвийг өмнөх оны гүйцэтгэлээс 37.3 сая төгрөгөөр бууруулж, нийт 16,828.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, баталсан ба 14,704.0 сая төгрөг зарцуулж, 2,124.0 сая төгрөгийн хэмнэлттэй мэт харагдаж байгаа боловч төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө 1,014.0 сая төгрөгөөр тасарсан нь бодит хэмнэлт гэж үзэх үндэслэлгүй байна.

